



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 4/03

Улаанбаатар хот

Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тусгайлсан зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 102 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/469 дүгээр захирамж, 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан газрын “Дүрэм”-ийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/469 дүгээр захирамж 1.2, 1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчмыг нэгдүгээр, Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнээс өдөр тутмын хэрэгцээний сүү, талх тээвэрлэх ачааны автомашиныг “Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага” MNS 5343:2011 стандартын шаардлага хангасан байдлыг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, тусгайлсан зөвшөөрлийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнээс өдөр тутмын хэрэгцээний сүү, талх тээвэрлэдэг аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллахыг Тээвэр, логистикийн хэлтэс /Г.Баасан/-т, Тээврийн хяналтын хэлтэс /С.Нямдорж/ нарт тус тус үүрэг даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Тээврийн газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/07 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ОТГОНБААТАР



1115108253 2117428

D:\alban_khereg\Явсан бичиг 2017\TUSHAAI.docx

1150500011

